



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 102

Залаа

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ТУХАЙ**

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, 35 дугаар зүйлийн 1.14 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2018 оны 192,А/243 тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, хоолны

газар, үсчин гоо сайхан, дугуй засвар, цех, дэлгүүрүүд, албан байгууллагууд, айл өрхүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын хураамжийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсүгэй.

3.Өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хэмжээгээр сар бүр Эрчим хүчний үйлчилгээний төлбөртэй хамтатган төвлөрүүлж, хог хаягдлын хураамжийн орлогоос 80 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласугай.

4.Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогыг хог хаягдал цуглуулах, ачиж тээвэрлэх, булшлах зардалд зарцуулан ажлын үр дүн, гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

5.Монгол улсын захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Цэнгэлмаа)-д даалгасугай.

6.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай" Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 70 тоот тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА Н.ЖАРГАЛСАЙХАН